

Мэргэн ноёны хошуу
Хөвсгөл сум

Академич Н.ИШЖАМЦ, Л.ЧИНРАВВАНЧИГ

Монгол орон, Монгол улс, Монгол үндэстэн угсаатны түүхийн ерөнхий тойм олон улсын монгол дорно дахинч эрдэмтдийн нөр их судалгааны ачаар нэгэнт нилээд тодорхой болоод байгаа билээ.

Цаашид түүнийг улам нарийвчлан гүнзгийрүүлж судлахад Монгол улсын орон нутгийн түүхийг нягтлан судлах явдал чухал. Тэр зорилтын үүднээс сүүлийн хориод жилийн дотор манай эрдэмтэд хуучин шинэ зарим аймаг сумдаас түүхийг судалж төв ба орон нутагт зарим бүтээл хэвлэн гаргасан буй.¹ 1994-1995 оны үест бид говь Мэргэн засгийн хошуу, түүнээс үүсэл гарвал бүхий Хутагт уулын хошуу, Дорноговь аймгийн Хөвсгөл сумын түүхийг архивын баримтаар судлан үзэхэд бузгай олз омогтой байж болмоор байдал ажиглагдаж байв.

XVI зууны үед Батмөнх Даян хааны отгон хөвгүүн Гэрсэнз жалайр хунтайжийн долоон хөвгүүн Ар Монгол, Халхын хант улсын ханлигийг хуваан захирах болсноор Халхын долоон отгон-хошуу, түүний дотор мөн говь Мэргэн ноёны хошуу бий болсноор Халхын долоон отог-хошуу, түүний дотор мөн говь Мэргэн ноёны хошуу бий болсон түүхтэй.

Тухайн үед Халх Монголыг Абтай хан толгойлж, одоогийн Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгийн нутгийг бүхэлд нь хамарсан Их Говийн тэр нэгэн том хошууг түүний дүү Абахай мэргэн ноён захирч байжээ.² Тус хошууг Мэргэн цолтой засаг ноён толгойлж байсан учир XV-XVII зууны үед Мэргэн ноёны хошуу, Мэргэн засгийн хошуу гэдэг байсан.

XVII зууны үед Мэргэн засгийн хошууг жонон цолтой Гүрших ноён захирч байсан бөгөөд гагцхүү Халхын ханлиг Манжид эзлэгдсэний дараа уг хошууны засаг ноёны жонон цол нь хасагдаж, оронд нь ван цол олгосноос хойш Мэргэн ноёны хошуу нь Говь мэргэн вангийн хошуу гэгдэх болсон юм.

Манж нар Монгол улсын төв гол хэсэг Ар Монголыг эзэлж аваад нэн даруй 34 хошуу болгосоны дотор Мэргэн вангийн хошуу нь бас хэд хуваалгагдан жижгэрч, үндсэндээ зөвхөн одоогийн Дорноговь аймгийн нутгийг хамрах болсон байна. Тэглээ ч гэсэн Мэргэн вангийн хошуу нь

1. Б.Өлзийсүрэн. Халхын Сэцэн хан аймгийн хураангуй түүх. Өндөрхаан. 1993. С.Чулуун, зөвлөх Г.Дүйнхэржав. Хатанбулагийн алтан ном. УБ. 1994.

2 Д.Гонгор. Халх товчоон. 1. редактор Ш.Нацагдорж УБ. 1970. 180-181-р тал

Манжийн ноёрхол (1691-1911), Богд хаант Монгол улс, (1911-1921)³ Ардын засгийн эхний үед 1924 оныг хүртэл дотроо 12-13 сумтай нэлээд том хошуу байв.

Мэргэн вангийн хошууны баруун урд талын Хутаг уулын орчин дахь одоогийн Дорноговь аймгийн Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах сум, Өмнөговь аймгийн зүүн өмнө талын Галбын говийн нэг хэсэг нь бүхэлдээ тус хошууны нэг томоохон отог, дараа нь сум болсон байжээ.

Манжийн ноёрхолын сүүлч, Богд хаант Монгол улсын үед Хутаг уулын тэрхүү сум нь зүүн, баруун хоёр хэсэгт хуваагдаж хоёр сум болоод Цэдэвдорж, Дэмбэрэлсамбуу (Дэмбээ) хэмээх хоёр зангид тус тус захирагдаж байжээ.

1923 онд ардын засгийн газраас аймаг, хошуу, сумдын нэрийн хан, ноён, занги нарын нэрээр нэрлэхийг болиож, уул усны нэрээр болгоход Мэргэн вангийн хошуу нь Хутаг уулын хошуу хэмээн нэрлэгдэх болжээ.⁴

1924 оны 6-р сарын 25-ний Хутаг уулын хошууны Цэдэвдорж, Дэмбэрэлсамбуу нарын сумыг тус тус хоёр хувааж, уул хошууг 4 сумтай болгоод Цэдэвдоржийн сумын Хөвсгөл, Хатанбулагийн хэсгийг Цээл уулын сум, Хөвсгөл, Улаанбадрахын хэсгийг Гуа уулын сум хэмээх болсны Гуа уулын сум нь дотроо говийн их, бага, дунд Гурван Хөвсгөл уулын орчин тойрныг хамарсан Хөвсгөл уулын багтай болжээ. Чухам тэр баг дараахан нь Хөвсгөл нэртэй байгуулагдан Дунд Хөвсгөлийн өвөрт төвлөсөн сумын үндсэн хэсэг болж, тус сум тэрхүү Хөвсгөл уул, Хөвсгөл багийн нэрээр нэрлэгдсэн учир Дорноговь аймгийн Хөвсгөл сум 1924 онд байгуулагдсанд тооцогдон ойгоо тэмдэглэдэг.

Говь Мэргэн ноёны хошуу анх байгуулагдахын өмнөх үеийн их тахилгатай уул байгаад дараа нь тус хошууны "Эрхэм сүлд тахилга бүхий онгон дархан" шүтлэгийн эзэн болсон, алс холоос сүндэрлэн харагдагч Хутаг уулын гол оргилын тахилгын их овоо Хөвсгөл, Хатанбулаг сумын нутгийн зааг дээр орших бөгөөд хоёр сум уламжлал ёсоор гурван жил тутам нэг удаа нийлж их тахилга хийсээр ирсэн байна. Хутаг уулын зүүн хэсэг нь Хөвсгөл Хатанбулаг сумын нутгийн зааг дээр орших бөгөөд хоёр сум уламжлал ёсоор гурван жил тутам нэг удаа нийлж их тахилга хийсээр ирсэн байна. Хутаг уулын зүүн хэсэг нь Хөвсгөл сумын нутагт, баруун хэсэг нь Хатанбулаг суманд харъяалагдаж буй. Хутаг уулын дэд оргил, түүний бага тахилгын Бурхант овоо Хөвсгөл сумын нутагт оршдог. Хөвсгөл сумын төв хэсэгт тус суманд алдар нэрээ хайралсан говийн их, бага, дунд Гурван Хөвсгөл уул оршдог бөгөөд дээр дурдсан Гуа уул хэмээх Гуа тээг мөн сумын зүүн хэсэгт

3 Богд хаант Монгол улсын тусгаар тогтнол, автономит эрхийг 1919 оны эцсээр Сүй Шүчжэнь тэргүүтэй гамин цэрэг устгасан боловч 1921 оны эхний улиралд Оросын цагаантны хүчээр сэргээгдэн түүний эрхшээл нөлөөн доор ч гэсэн ардын хувьсгал хүртэл бодитой оршин тогтнож байсан

4. Д.Даваадорж, Д.Гомбожав, Г.Ломбуу, Дорноговь аймгийн хураангуй түүх. редактор Г.Лувсанцэрэн. Сайншанд, 1984, 18-19-р тал

дүнхийн харагдана.

Төв Ази, Монголын Их говийн хамгийн өндөр нь биш агаад ямар ч ой модгүй, харин аргаль, янгир, шилүүс бүхий Хутаг уул яагаад тэгж эрт дээр үеэс Говь Мэргэн засгийн хошууны нийтийн гол тахилгатай шүтээн болсон бэ гэдэг асуудал төдийлэн тодорхойгүй. Гэвч уг асуудлыг геологи, газар зүйн талаас нь сонирхон үзвэл даян дэлхий нэлэнхий их далайн усаар бүрхмэл байгаад гурван тэрбум жилийн өмнө эхний тив өргөгдөн цухуйхад анх Хангайн нуруу, дараа нь одоогоос 900 сая жилийн өмнө Говийн Хутаг уул тус тус гарч ирсэн байх юм. Түүнээс гадна Хутаг уул нь гол төлөв шохойн чулуулгаас бүтсэн Атлантын далайн эргийн уулстай бүтэц бүрэлдэхүүний талаар нэлээд төсөөтэй ажээ. Энэ бүхэн эрт, дундад үеийн хүмүүсийн оюун сэтгэхүйд ямар нэгэн замаар тийн мэдрэгдэж, онцгой их шүтлэг бишрэл төрүүлсэн юм биш байгаа гэлтэй.

Бөө мөргөл, буддийн шашны аль алины ёсоор тахигдаж ирсэн Хутаг уулын эзэн савдаг нь тохомтой том аргал угалзаар хөлөглөсөн урт гээзэгтэй, хар хүрэн хантаазтай эр хар хүний сүнс сүг байдаг бөгөөд Нийслэл Хүрээний өмнөх Богд хан уулын зүүн, зүүн хойт талын багавтар нэгэн уулын эзэн охин савдагтай гэрлэсэн учир үе үе түүн дээрээ очоод заримдаа эзгүй байдаг гэсэн домогтой. Хутаг уулын эзэн нь эр хүний чанар дүртэй хар зүгийн савдаг учир уг уулан дээр эм хүн гарч болохгүй, гэвч түүнд тахилга тавилгын зариулгаар архи, махнаас гадна сүү цагаан идээ өргөхөд харшилдаггүй, харин ч сайн гэнэ. 5 5 Хөвсгөл сум, Хутаг уулын хошууны уул усны, хүмүүсийн намтар, түүхэн домгийн их мэдлэгтэн Д.Ядам гуай нарын зэрэг ахмадын хүүрнэл ярианаас авсан зүйл. Хөвсгөл сумын нутагт Хутаг уул шиг том биш атугай ч мөн эрт дээр үеийн "эрхэм сүлд тахилга бүхий онгон дархан уул, овоо, ус" нилээд бий. Жишээлбэл: Авдрантай, Гурван тахилгат, Ачит Хар овоо, Шаваг сүйхэт, Дэрсэн ус, Далайн ус гэх мэт.

Тийм сүлд тахилгагүй хэрнээ ихэд нэр гарч хүндэтгэгдэн хайрлагдсан уул ус байсаар ирсний заримыг дурдвал: Хөвсгөл сумын Төв хэсэгт оршдог Говийн Гурван Хөвсгөл уул, Гуа тээг, Орлой гурван зээрд, Онгон гурван шанд, Асман гурван булагийг хэлж болно. Тэдгээр бүх уул, овоо, ус сэлтийг Хөвсгөлчүүд тахин шүтэж, хайрлан хамгаалж байгаль орчноо бүрэн бүтэн, цэвэр ариун хадагалж ирсэн түүхтэй билээ.

Мэргэн вагийн хошуу, Хөвсгөл суманд том нуур, өргөн урт мөрөн байхгүй атал энд тэндгүй тийм далай, ийм далай, далайн улаан цав, элсэн далай, тэр байтугай "Далай уул" гэх мэт газрын нэр байн дайралддаг. Дээр дурдсанчлан Монгол орон, Төв Ази нь дэлхий нийтийг бүрхсэн нэлэнхий их далайгаас анх өргөгдөн гарсан боловч түүний говь, хээрийн бүс 400 сая жилийн өмнө тэнгисийн ёроолд орж 50 сая жил болоод дахин өргөгдөж хуурай газар болсон. Гэтэл 270 сая жилийн өмнө нийт говь нутаг гурав дахь удаагаа тэнгисийн усаар хучигдаж 20 сая жил болж байж Эцэст нь бүр мөсөн хуурай газар болсон гэдэг. Тэр бүхэн хүн төрөлхтөн үүсэхээс

өмнө олон сая жилийн өмнө болж өнгөрсөн учир хүн мэдэх учиргүй байсан мэт боловч эртний Хятадын түүх сударт одоогийн Дорноговь аймгийн нутгийг бүхэлд нь "Хатсан далай", "Ширгэсэн тэнгис", "Хуурай нуур" гэсэн утгатай үг үсгээр тэмдэглэн үлдээсэн байдаг. Харь орны хүмүүс Монголын говьд тэнгис байсныг төсөөлөн мэдсэн байхад уугуул Мэргэн вангийн хошууны халх нар огт мэдэхгүй байхын аргагүй байсан болов уу. Юу ч гэсэн хангай, хээрийн бүсэд байдаггүй "далай" говиор дүүрэн Хөвсгөл сум даяар дайралддаг, тэндэхийн уул нуруу нь хүртэл "далай" болсон байдаг явдал сонин бөгөөд бас ч санамсаргүй тохиолдол биш биз ээ.

Монгол орон хэд хэдэн удаа далай, тэнгисийн ёроол байж, тэдгээрийг татран ширгэсний дараа асар их загас жараахай бүхий том нуур, өргөн мөрөн, ой хөвч, ургамал амьтнаар баян байсны ул мөр хаа сайгүй байдаг. Чулуун нүүрс Монголд хаана байхгүй билээ? Мэргэн вангийн хошуу буюу Дорноговь аймгийн Мандах суманд чулуужсан модон ой байгаа, мөн аймгийн Гурван баян нь газрын тосны нөөцтэй бөгөөд түүнийг анх өрөмдөн ашиглаж байхад газрын тосны хамт акула хэмээх аварга загасны шүд, ясны зүйл гарч ирж байсан, бүхэл бүтэн хүний чинээ том загасны чулуужсан цогцос олдсоныг найман хүн өргөөд даалгүй газар алдан өрөөсөн загалмайг нь хугалсан буй. Мэргэн ван, Хутаг уулын хошууны Хатанбулаг сумын Эргэлийн зоо хэмээх том хавтан уулын огцом эрэгцэгээс 1920-иод оны үед Эндрюс тэргүүтэй америкийн шинжилгээний ангийхан анх үлэг гүрвэлийн араг ясны зүйл нээн олсон. Үлэг гүрвэлийн ясыг монголчууд хэзээнээс мэдэж, лууны яс гэдэг байсны дээр тэр балар эртний галавын үлэмж биет жигүүртний ясыг хангардь шувууных гэдэг байсан.

Одоогоос 2 сая орчим жилийн өмнө Монгол оронд хангай, хээр, говийн бүсийн ялгаа гарч, улмаар орчин цагийн ургамал, амьтны аймаг бий болоод эцэст нь нэг сая шахам жилийн өмнөөс хүн оршин амьдрах болсон гэдгийг та бид сайн мэднэ. Хүрэл зэвсгийн үед М.Э.Ө III-II мянганы үед нүүдлийн мал аж ахуй, нүүдлийн соёл зонхилох болсон. Төмөр зэвсгийн үед М.Э.Ө III-II зууны үед Монгол нутагт Хүннү гүрэн, М.Э.Ө I зууны үед Сяньби улс байгуулагдсан нь Төв азийн нүүдэлчид, өвөг монгол угсааны аймгуудын дунд үүссэн анхны төр улс, төр ёс, бичиг үсэг бүхий нүүдэл иргэншлийн эх үүсвэр байв. Тэдгээр улс гүрэн болон дараачийн Жүжан, Түрэг, Уйгур, Киргис, Кидан зэрэг нүүдэлчин улс аймгуудын олон аймаг, овгууд удаа дараалан өвөр хоорондоо хольцолдон ижилссээр IX-XII зууны Монголын Хамаг Монгол, Хэрэйд, Найман, Татар, Мэргид, Ойрад, Онгуд зэрэг аймаг ханлигуудыг бүрэлдүүлсэн. XI-XII зууны үед хожмын Мэргэн вангийн хошууны Өмнөговийн хэсэгт гол төлөв Найман, Дорноговийн хэсэгт Хэрэйд, түүнчлэн тэдгээрийн бүрэлдүүнд урьд нь орж нэгэнт бүр мөсөн монголжсон киргис угсааны цөөн тооны хүмүүс амьдарч байжээ. Одоо болтол Дорноговь аймгийн Хатанбулаг сумын баруун захаар дундад эртний Хэрэйд, Найманы хилийн заагийн олон арван километр урт бөгөөд том

хэмжээний гүвгэр шороо, чулуун зурвас байдаг. Хүрэл, төмөр зэвсгийн эхэн үе, Хүннү, Түрэг, дундад эртний монголын хадны зураг, хөшөө чулуу, хадны зураг болон бичээс Дорноговь аймгийн Хатанбулаг, Улаанбадрах сумын нутагт цөөнгүй бий.

XIII зууны үед Монголын үндэсний тулгуур төр Их Монгол улс байгуулагдсаны дараа уг нутгийн өвөг Монгол угсааны овог аймгийн хүмүүс нэмэгдэн ирж ижилсэн, Мэргэн засгийн хошууны уугуул Монголчууд болсон байна. Чухам тэдгээр Хамаг Монгол, Хэрэйд, Найманы зэрэг монголчууд нийлэн ижилсэн XVI зууны Монголын Халх түмний Мэргэн засгийн хошууны үндсэн хүн ам халхчууд болсон юм. Дараа дараачийн үеүдэд Мэргэн вангийн хошуу, түүний дотор мөн говийн Гурван Хөвсгөл нутагт уухан (аухань), баяд, түмэд, юншээбу, дөрвөн хүүхэд, цахар, харчин зэрэг янз бүрийн аймаг, ястны хүмүүс орж ирж нутгийн уугуул иргэдтэй уусан ижилссэн байна. Эдүгээгийн Хөвсгөл сумын иргэд бараг цөм Халх нар бөгөөд юншээбу, цахар зэрэг гаралтай нэг нь түүнийгээ бараг мэдэхгүй шахам болсон харагдана.

Мэргэн ван, Хутаг уулын хошууны Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумдын нутагт XIII-XIV зуун, түүнээс хойшхи үеийн түүх археологийн ховор нандин дурсгал, газар усны болон түүхэн домог яриа багагүй үлджээ. Хатанбулаг сумын урд хэсэгт, Монгол-Хятадын хилийн наахна Хатны булаг хэмээх ширгэдэггүй ундаргатай нэгэн сайхан булаг байдаг нь Чингисийн Хулан хатны нэртэй холбоотой. Булгийн ар талд зүүн баруун тийш хөндөлссөн урт улаан уул, мөнхүү булгийн баруун зүүн хоёр талд хоёр том өндөрлөг бий. Чингис хаан тангадын эсрэг аян дайнд явахдаа Хатны булшийн тэнд их цэргийн хамт буудаллан цэрэг агтаа амрааж, хүчээ сэлбээд хил гардаг байсан, тэрхүү булгийн орчин тойронд их том бэхлэлт хэрмийн үлдэгдэл одоо ч байгаа бөгөөд дотроос нь том, жижиг гэр тэрэгний цөн, нум сумны зэв зэрэг зүйлс багагүй олддог. Хэрмийн дотор, гадна тухайн үеийн монгол цэргийн булш бунхан ч нэлээд хэд байдаг. Хатны булгийн тэнд Монгол Тангадын хилийн харуулын ар талын хилийн цэргийн байнгын харуулын нэг том төв байж, булгийн арын улаан уул, хоёр талын өндөрлөг дээрээс морьт цэрэг өдөр, шөнөгүй урьдах уул, түүний наад талын өргөн уудам хөндийг ширтэн хянаж байсан байдал илэрхий мэдэгдэнэ. Чингис хаан 1226 оны намар Тангадын эсрэг сүүлчийн аян дайнд мордоод замын зуур их Говийн Харбуха гэдэг газарт хулан агнаж яваад мориноосоо унаж хүнд шарх олсон газар нь Хатаны булгийн зүүн хойд талд асар холгүй орших маш том бөгөөд өргөн хавтгай оройт Эргэлийн зоо мөн бөгөөд тэр уул алсаас харахад үнэхээр том бух мэт дүнсийн харагдана. Шархатсаны дараа Чингис хаан бага зэрэг урагшлан бууж бие сувилан байсан газар нь тухайн үед Чуурха⁶

нэртэй байсан хатны булаг мөн бололтой байдаг.

Хөвсгөл сумын нутагт Чингисийн нэртэй холбоотой зүйл бага мэт боловч Дарьт толгой гэх мэтийн газар байх сацуу түүний нэртэй холбогдон домог яриа цөөнгүй байдаг.

Хөвсгөл сумын зүүн хэсэгт Сүлдэнэ хөх толгой гэдэг нэгэн сонин газар бий. Тэнд эрт цагаас Абахай ноён, Гүрших нарын хадгалан тахиж байсан Чингисийн их цагаан сүлдний найман дагуул цагаан тугны нэгийг залан байрлуулаад үе улиран тахиж тунхаглсаар иржээ. Их цагаан сүлдний найман цагаан тугийн хоёрыг Өвөр Монголын эзэн хороонд, нэгийг Шилийн голд, нэгийг Ар Монголын Хархорум, Эрдэнэ зуугийн Тэнд, нэгийг Увсад, нэгийг Хөвсгөл суманд тус тус байлгаж, тахиж тавигласаар ирсэн бөгөөд Алтан ордонд нэг байсан нь Орост үлдсэн гэдэг домог яриатай. 1940 оныг хүртэл Хөвсгөл суманд тахигдаж байсан цагаан туг бусад ихэнх газар дахийн нэгэн адил том эсгий гэрт тооноор нь цухуйн байсан бөгөөд эхлээд тугч отгийнхон, дараа нь тугч багийнхан хэмээх Чингисийн угсааны нэгэн тайж тэргүүтэй айлууд хариуцаж байжээ. Түүнчлэн тэр хавийн Бөөргийн хийд "Сүлдний хурлын жас" хэмээх тусгай аж ахуйтай, сүлдийг хадгалан хамгаалах, тахиж тунгахад зориулсан бэлэн сан хөмрөгтэй байжээ. Уг сүлд, түүнийг хадгалж хамгаалах, тахиж тунгах тухай Сүлдэнэ овооны тугч П.Доржийн өргөмөл хүргүүн, ахмад зүтгэлтэн, тугийг тахирад олон удаа биечлэн оролцож сайн мэдэх болсон Л.Чинравванчиг тусгай өгүүлэл, танилцуулга бичиж нийтлүүлсэн буй.⁷

Н.Ишжамц, Л.Чинраавванчиг, Хутаг уулын хошуу, Хөвсгөл сумын түүх. Англи товчлолтой, хянан тохиолдуулсан Ц.Содномцэрэн. УБ. 1997.74-77-р тал Мэргэн вангийн хошууны засаг ноён, мэргэн Жонон Гүршихийг 1705 онд нас барсны дараа одоогийн Улаанбадрах, Хөвсгөл сумдын зүүн хэсэг дэхь Гуа тээг уулын зүүн урд үзүүрт бурхант нэртэй тусгай нэгэн дов болж харагдаж буй. Түүний дээд тал нь засмал оройтой, ар талаасаа гардаг шаталсан замтай, зарим зүйл нь нилээд эвдэрч хуучирсан боловч ухаж малтагдаагүй, үндсэндээ бүрэн бүтэн байгаа. Агваангончиг хутагтын Хойчийг XVIII зууны үед залгамжилж байсан хоёр, гурав, дөрөвдүгээр дүрийн говийн ноён хутагтууд тус нутагтай чухам ямар холбогдолтой байсан нь тодорхойгүй. Харин 1804 оны 1-р сарын 7-8-ны үес Хөвсгөл сумын хойт захын Шувуун шандны дэргэд мэндэлсэн говийн тавдугаар ноён хутагтын нэрэмжит, шарын шашны Данзанрабжайлин хийд хэмээх Хонгорын хурал 1939 оныг хүртэл оршин байсан нь орон нутаг судлал, архивын баримтаар сүүлийн үед тодорхой болов.⁸ Данзанрабжайлин хийд Хөвсгөл сумын зүүн өмнөд хэсэгт, улсын хилийн цаахна байсны туурин дээр очиж үзэхэд сүмийн байшин барилгын үлдэгдэл овгор шороонууд туйлуу сэлтээс өөр юм ил

7. Л.Чинравванчиг. "Чингис хааны цагаан туг"

8. Монгол Улсын Түүхийн Төв Архив (МУТТА), ф.65, хн, 125, 31 б, ф.65 шинэ, хн. 15,14а, ф65 шинэ, хн. 30,84а.

үзэгдэхгүй, харин археологийн малтлага хийвэл нэлээд зүйл гарч ирэх төлөвтэй үзэгдэнэ.

Нутгийн хүмүүс, урьд нь тэнд очиж байсан Буддын шашны ба орчин цагийн өндөр боловсрол хослуулан эзэмшсэн Ц.Гомбосүрэн хэмээх тус нутгийн нэгэн өвгөн хутагтын ярихаар бол сүмийн гол дугана нь түвд маягийн хоёр давхар байшин, өмнө талдаа хуучны дэл сүүлэн туг, хадаг Яндар болсон том монгол өргөө гэртэй байсан ажээ. Түүнийг дүрсэлсэн гар зургийн хуулбарыг Дорноговь аймгийн түүхчдийн холбооноос эрхлэн энэ 1997 онд Улаанбаатар хотноо цөөн хувь нийтлүүлсэн "Хутаг уулын хошуу, Хөвсгөл сумын түүх" хэмээх бэсрэгхэн товхимлын нүүрэн талд хэвлэснээс үзэж сонирхох боломжтой. Данзанрабжайлин хийд нь Хонгорын их жас, хойн жас, Майнийн жас, Юумын жас, Нүнгийн жас, Зулын жас, Дончодын жас хэмээх долоон жастай байсан байна билээ.⁹ Хонгорын хурал Данзанравжайтай ямар нэгэн холбогдол бүхий болох нь 1920-30 оны үес говийн долдугаар ноён хутагт Өвөр монголын зүг явахдаа түүгээр тусгайлан дайрч шашны янз бүрийн ёслол үйлдүүлээд одож байснаар давхар нотлогдож байх мэт

Бас нэг сонирхолтой зүйл бол хангайд ганцхан Хөвсгөл нуур байхад говьд яагаад их, бага, дунд гурван Хөвсгөл уул, Хөвсгөл нэртэй сум байдаг билээ гэдэг асуудал юм. XVIII зууны дундуур Амарсанаа, Чингүнжав нарын бослогыг даруулахаар Манжийн төрийн зүгээс өвөр монгол, Хятад, манж жанжин нараар удаа дараа толгойлуулсан гурван удаагийн их цэрэг гаргасан нь амжилт ололгүй бут цохиулсан. Тэнгэрийн тэтгэсэн хаан Ар Халхын Хангай нутгийн Их тамир орчны хонгууны засаг ноён, өөрийн хүргэн эфү Ц.Цэнгүнжаваар их цэргийг удирдуулан байж бослогыг дарсан. Гэсэнч халх жанжны мэдэлд Монгол цэрэг төвлөрсөн явдлаас болгоомжилсон ч юм уу, яасан юм бэ бүү мэд, ямар ч байсан Цэнгүнжавыг эх орон, цэрэг ард, хамаатан саднаас нь бүр мөсөн салган хөндийрүүлж, нийслэл Бээжинд ихээхэн том сайд болгож, тусгай ордон харшид ихээхэн хүндтэй мэндтэй байлгах болжээ. Гэвч Цэнгүнжав монгол хүн болохоороо эх нутаг, хамаатан садан, цэрэг ард, мал мах, цагаан идээ, ан гөрөө сэлгээ санагалзан нутгийн зүг тэмүүлдэг байжээ. Манжхаан түүнд түүний нутгаас зоож болох бүх юмыг ордонд нь зөөлгөн авчруулж байхын тулд албан ёсны харчин өртөөний зүүн талаар бас нэгэн тусгай зориулалтай өртөө маягийн юм байгуулжээ. Тэгэхдээ анх Цахараас Ар Халхын хил хүртэл хэдэн суурь өртөө байгуулж, дараа нь Цэнгүнжавын нутгийн Их Тамир, Зая бандидын шавийн гурав, дөрвөн сумнаас нэгэн тайж, хэсэг занги нараар толгойлуулсан хэсэг айлуудыг мал хөрөнгийнх нь хамт Говь руу шилжүүлэн нүүлгэж, ихэнхийг одоогийн Хөвсгөл сумын зүүн урдуур цахар өртөөнийхнийг тосгуулан байруулж.¹⁰

9 МУТТА. Ф.65, ХН, 126,31 б.

10. МУТТА. М.9, т.3, хН. 4490, 13 ба 22-р бичиг

Хангай газрын тэдгээр айл өрх уугуул нутгаа санаж, очсон газрын заримд Чулуутын гол, Дэлгэр худаг гэх зэрэг нэр өгөөд түүнээс нилээд хойгуур нь хөхрөн харагдагч харьцангуй том гурван уулыг Хөвсгөлийн уулс гэж нэрлэсэн нь яван явсаар тус нутгийн уул ус, сум багийн нэр болсон. Тэнд хангайгаас нүүж очсон айлууд нь сахар өртөөнийхнийг тосгуулан тавигдсан учир тосгоныхон, тосгончууд гэж нэрлэгдэх болжээ. Эфү Цэнгүнжавын угсааны Наянт вангийнхан XIX зууны эцэс, XX зууны эхэн хүртэл тосгоныхныг өөрийн хошууныхан хэмээн үзэж буцаан татаж авахаар хэд хэдэн удаа оролдож байжээ. Тэгээд Богд Хаант Монгол улсын үеэр 1913 онд тэднийг мал хөрөнгийнх нь хамт цөмийг Наянт вангийн хошуунд албан хүчээр татаж авсан боловч хүн малын аль аль нь хангайд идээшихээ байж өвдөж зовоод уван цуван Гурван Хөвсгөл нутагтаа ирж бүрмөсөн үлдсэн байдаг.¹¹ Тэд уугуул нутгийнхантай хольцолдож ижилсээд одоо ялгагдах юмгүй болсон ч гэсэн тосгоныхон гэдэг нэр нь хараахан мартагдаагүй байгаа. Тосгоныхны олонхи нь Хөвсгөл нутгийн янз бүрийн газарт тархан тус тусын нутгийнхантай төрөлсөн ижилссэн тул Хөвсгөл сумыхныг нийтэд нь Ар хангай, Их тамир нутгийнхантай түүх, угсаатны зүй, антропологийн хамааралтай хэмээн үзэхэд бүрэн болох бөгөөд мөнхүү хангайгаас гарвал удамтай Абахуй ноён, Гүрших жонон, Агваангончиг хутагт нар болон тэдний төрөл садан, ойрын албат, шавь, удам угсааныхан нараар дамжин хангайчуудтай удам угсааны давхар холбогдолтой хэмээмээр.

Мэргэн ван, Хутаг уулын хошуу ялангуяа Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумд нь Монгол улсын өмнөд хязгаарын алс бөглүү нутаг байсан боловч амьдрал хөгжлийн хувьд тийм ч харанхуй зэрлэг бүдүүлэг байсангүй. Ардын хувьсгалын эхний үеийн сургууль соёл байгуулагдаагүй үеийн тоо бүртгэлээс үзэхэд Хутаг уулын хошуу 585 өрх, 6100-аад хүн амтай байсны 1,5-1,8 хувь нь үндэсний монгол бичигтээ байсны дээр олон тооны лам хуврагуудын зарим нь бас монгол бичиг мэддэг байсныг тооцвол хүн амын 2% орчим нь монгол бичигтэн байсан явдал үндсэндээ тодорхой болж байна. Лам хувраг буюу түвэд бичигтэн 22,8 хувь, Манж бичигтэн түшмэд эрдэмтэд, 0,14 хувь, хятад бичигтэн 0,003 хувь байжээ. Орос хэл мэдэх хүн ганц хоёроос илүү байсангүй. Тэд бүгд нийлээд хүн амын 25 хувийг эзэлж байх учир ардын хувьсгалын өмнө тус нутагт бичигтэн хүмүүсийн тоо барагцаалбал хүн амын дөрөвний нэгтэй тэнцэж байна гэсэн дүн шинжилгээ хийж болох байна.

Академич Б.Ренчин, Ш.Лувсанвандан, Ц.Дамдинсүрэн нар хувьсгалын өмнөх монгол бичигтний тоог 15 хувиас доошгүй гэдэг байсан бөгөөд үнэхээр Монгол орны төв ба умард хэсэгт монгол, түвэд, манж, хятад, орос хэл бичиг мэдэгчийн тоо мэдэгдэхүйц илүү байсны дээр англи, Япон хэлтэй цөөн зарим хүн байсан зэргийг бодолцвол хувьсгалын өмнөх хүн амд үндэсний

болон гадаад хэл бичиг мэдэгчийн тоо 30-иад хувь буюу хүн амын бараг гуравны нэгд дөхөж очих тоо гармаар шинжтэй байгаа юм.

Хутаг уулын хошуу 34 хүрээ хийдтэй байсны 8 нь Хөвсгөл сумын нутагт байсан бөгөөд тэд цөм урьд бидний боддог шиг мунхаг бүдүүлгийн туйл байсангүй, харин ихээхэн чухал эрдэм соёл, соён гэгээрэл, суурьшмал иргэншлийн төв байсан байна. Чухам тэндээс ихээхэн номтой, эрдмийн зэрэг цолтой Хутагт хувилгаад, ихэс лам нар гарч байжээ. Тэдний нэг болох Данзанрабажай нь "Говийн догшин ноён нутагт" "хувилгаан аграмба цорж их ламтан", "аймгийн ноёдоос эхлэн олонд итгэл аврал болсон ачит багш" цол гуншинтай байжээ.¹² Түүнийг лам гэхгүй, Далай лам, Банчэн эрдэнэ, Жибзундамба нарын зиндаанд дөхүүлж, чухамхүү "бламтан" гэдэг байсан нь санамсаргүй хэрэг биш юм. Хутаг уулын хошуунд 1923-1924 оны бүрэн бус тоо бүртгэлээр Хутагт хувилгаад 5 байсны дээр аграмба 6, рабжимба 7, габж 24, маарамба хэд хэд байсан байх бөгөөд¹³ Бандида, аграмба, рабжимба нар нь одоогийнхоор бол академич, сурвалжлагч гишүүдтэй дүйх цол зэрэг, лхаарамба, дооромбо, маарамба, габж нь доктор, дэд доктортой ойролцоо зэрэг цол байсныг анхаарвал тэнд эрдмийн зэрэг цолтны хувьд тоо хэмжээ нь чамламааргүй байсан үзэгдэнэ. Одоо тус сумнаас төрсөн шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн 1, академич 3, профессор доктор 3, дэд доктор 4, дээд мэргэжлийн боловсон хүчин олон болоод байгаа.

Ардын хувьсгалын дараа Хутаг уулын хошуунд 1923/24 оны үед, Хөвсгөл сумын төвдөөр 1926-27 оны үеэс орчин цагийн боловсрол олгох бага сургууль анх байгуулагдсан бөгөөд тэр цагаас хойш тус сум нь Монгол улсын бусад аймаг, сум, багуудын хамт капиталист биш замаар замнаж 1989 оныг хүртэл социалист байгуулалт хэрэгжүүлэн хөгжиж байсан билээ. Коммунизмын нөлөө, большевикууд тэргүүтэй коминтерны эрхшээл нөлөөнд автаж, хүрээ хийд, лам хувраг, хуучин сэхээтэн, үндэсний бичиг соёл, хувийн өмчийг устган, коммун хамтралд орж, хөдөө орон нутаг даяар нэгдэлжин, эх оронч үзлийг хяхан хавчих, хүний эрх, ардчилалыг хязгаарлах зэрэг эсэн бусын хэлмэгдүүлэг завхрал гарч байсан боловч Орос, Зөвлөлтийн ард түмний дэмжлэг туслалцаатайгаар Монгол улс, түүний дотор мөн Дорноговь аймгийн Хөвсгөл сум Хятадаас бүрэн тусгаарлаж, ард иргэд цөм кирилл гарвалт орос үсэгт суралцан бүх нийтээр бичигтэн болж, техник эдийн засгийн талаар дэвшин хөгжөөд Орос, Европын соёл иргэншилд орж нүүдэл, сууршил хосолсон орчин цагийн соёл иргэншилт улс орны байдалтай болж байв. Хөвсгөл сум ардын хувьсгалын 8 партизан, хувьсгалт тэмцлийн 1 ахмад зүтгэлтэн, 54 ахмад дайчин, 44 аварга, сайн малчин, ажилчин, 3 хөдөлмөрийн баатар, гавъяат ажилтан, 20 соёл урлагийн гавъяат зүтгэлтэн, тэргүүн цолтон ба улсын их хурлын гишүүн байнгын хорооны дарга нэгтэй.

12. МУТТА. М. 9, т. 3, хн. 4267, 39-р бичиг. 4268, 49 ба 57-р бичиг. ФМ.16, т.1, хн. 16.

13 МУТТА, Ф65, хн, 4.

1989-90 оны ардчилсан хувьсгалын үеэс эхлэн хуучин маягийн социализм, коммунизмаас бүр мөсөн татгалзаад арчдилал, шинэчлэл, зах зээлийн тогтолцоонд шилжиж, мандал бадрал, шударга ёс, хүний эрхийг дээдэлсэн хүмүүнлиг, иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилт тавин амьдарч ажиллаж байна. Хөвсгөл сумыг эдүгээ Л.Батмөнх, Н.Борхүү, Ц.Чулуунбаатар, Д.Дашбадгар нар удирдан ажиллаж байгаа. Тус сумнаас Улсын Их Хурлын гишүүн, байнгын хорооны даргаар Ц.Шаравдорж сонгогдон ажиллаж байгаа болно. Тэр бүхний тухай "Хутаг уулын хошуу, Хөвсгөл сумын түүх" (УБ. 1997) товхимолд тодорхой дурдсан буй.

1997 оны 8-р сар